



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/615

Мөрөн сум

Засаг даргын дэргэдэх Мэдээллийн
технологийн “Хурдан” клуб
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 7 дугаар зорилтын 7.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6 дахь заалтын 6.1 дэх хэсэг “Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.1.1.10 дахь заалт, 2.1.1.31 дэх заалт, 2.2.2.1 дэх заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 321 дугаар зүйлийн 321.1.7 дэх заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг сайжруулах, инновац хийх чадвартай бүтээлч иргэдийг бэлтгэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих зорилгоор Мэдээллийн технологийн “Хурдан” клубийг Засаг даргын дэргэд байгуулж, клуб байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Тус клубийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга (Д.Сумаадагва)-д даалгасугай.

3. Тус клубийн үйл ажиллагааг идэвхжүүлж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг Боловсролын газрын дарга (О.Бадраа), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга (Ц.Оюун-Эрдэнэ), ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4. Сурагчдын “Хурдан” клубийн оролцоог хангаж, үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллахыг сумдын Засаг дарга, газар, хэлтэс, агентлаг, аж ахуйн нэгжийн удирдлагуудад уриалсугай.

5. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гандэлгэр)-д даалгасугай.

ДАРГА


Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712011866

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр
сарын 15-ны өдрийн 1/615 дугаар
захирамжийн хавсралт

УДИРДАМЖ



2024 оны 11 дүгээр сарын 15-ны

Мөрөн сум

Засаг даргын дэргэд мэдээллийн технологийн
“хурдан” клуб байгуулах

Нэг. Үндэслэл

“Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан “Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт мэдээллийн технологийн мэдлэгтэй, инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болох, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах шаардлага үүсэж байна.

Хоёр. Зорилго

Ахлах ангийн сурагчдын мэдээлэл технологийн ур чадварыг дээшлүүлж, цахим ур чадвартай иргэдийг нэмэгдүүлэхэд “ХУРДАН” клубын зорилго оршино.

Гурав. Зорилт

1. Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдаас бүрдсэн, мэдээллийн технологийн “Хурдан” клуб байгуулах;
2. Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс клубийн сурагчдад харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновац, дэвшилтэт технологи, кибер аюулгүй байдал, төрийн цахим үйлчилгээ, аймгийн цахим шилжилт гэх мэт сэдвээр сургалт зохион байгуулах;
3. Сурагчдын чөлөөт цагийг цахим ур чадварыг дээшлүүлэх сайн дурын ажилд оролцуулах замаар үр бүтээлтэй өнгөрүүлэх;
4. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг сурагчдын санаачилгаар зохион байгуулах;
5. Үндэсний хэмжээнд цахим элч, сайн дурын ажилтныг бэлтгэх;
6. Клубийн гишүүдийн өөрсдийн санаачилгаар төрөл бүрийн цахим нөлөөллийн аяныг өрнүүлэх;
7. Клубийн гишүүдийг мэдээллийн технологийн чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрт хамруулах;

Дөрөв. Оролцогч талууд

4.1 Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Ерөнхий боловсролын сургууль, холбогдох бусад байгууллагууд,

Тав. Хамрах хүрээ

5.1 Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид

- Аймгийн төвийн сургуулийн сурагчид;
- Сум тус бүрээс төлөөлөөлөл байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулсан байх;

Зургаа. Тавигдах шаардлага

- Мэдээллийн технологийн чиглэлээр суралцах, хөгжих хүсэлтэй байх;
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч байх;
- Бие даан суралцах дадалтай байх;
- Бусдыг уриалах, манлайлах чадвартай байх;
- Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс зохион байгуулж буй үйл ажиллагаа болон клубийн үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдах;
- Өөрийн эзэмшсэн мэдлэг, ур чадварыг олон нийтэд таниулах түгээх хүсэл, эрмэлзэлтэй байх;

Долоо. Клубийн онцлог

7.1 Клуб нь сурагчдын сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд сурагчид харилцаа холбоо, мэдээллийн технологийн ур чадвараа нэмэгдүүлэх төдийгүй гэр бүл, үе тэнгийн найз нөхөд, ахмад настан, сурагч дүү нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүхий л түвшинд цахим орчны зохистой хэрэглээ, дэвшилийг сурталчлан таниулна.

Найм. Клубийн давуу тал

8.1 “Хурдан” клубийн гишүүн нь “Цахим элч” бэлтгэх хөтөлбөрт хамрагдана.

8.2 Хөтөлбөрт ашиглах зөөврийн компьютер, хөдөлгөөнт төхөөрөмж буюу таблет зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдана.

8.3 Мэдээлэл технологи, цахим ур чадварын мэргэшүүлэх сургалтад хамрагдана.

8.4 Дэмжлэг үзүүлэгч байгууллагуудаас сайн дурын ажилтнаар амжилттай ажилласан тухай тодорхойлолт, ил захидал, батламж авна.

8.5 Харилцаа холбоо, мэдээллийн технологи сонирхогч хүүхэд залууст зориулсан гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамрагдах зэрэг давуу талтай болно.

Ес. Клубийн зохион байгуулалт

9.1 Клуб нь Зөвлөх-чиглүүлэгчтэй байх бөгөөд Зөвлөх-чиглүүлэгч нь Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан хаагч байна.

9.2 Клубын сурагчид нь дотроосоо ахлагч, удирдагчийг сонгож болно. Ахлагч удирдагч нь ерөнхий зохион байгуулалтыг хангаж ажиллана. Клуб нь сонирхлын дэд бүлгүүд байгуулан ажиллаж болно.

Арав. Дэмжигч байгууллага, дэмжлэгийн хэлбэр

10.1 Аймгийн Засаг даргын Тамгын газар

- Сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах

- Урамшуулал олгох
- Тэтгэлэг олгох
- Томилолтын зардал шийдвэрлэх
- Сурагчдын ажиллах орчин, аюулгүй байдлын хангах
- Бусад

10.2 Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар:

- Сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамруулах
- Дотоод гадаадын төсөл хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулах
- Бусад

10.3 Аймгийн төрийн цахим үйлчилгээний хэлтэс

- Клубийн ерөнхий зохион байгуулагчаар ажиллах
- Дэмжигч байгууллагуудын уялдаа холбоог хангах
- Холбогдох байгууллагуудтай харилцах үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Бусад

Арван нэг. Хүрэх үр дүн

- ✓ Мэдээллийн технологийн чиглэлээр суралцах сонирхолтой сурагчдын тоо нэмэгдсэн байна.
- ✓ Сайн дурын цахим элч, сургагч багш нар бий болсон байна.
- ✓ Сурагчдын мэдээллийн технологийн ур чадвар нэмэгдсэн байна.
- ✓ Төрийн үйлчилгээг цахимаар авах иргэдийн ур чадвар нэмэгдсэн байна.
- ✓ Сурагчдын үе тэнгийн нөлөөллийн аяныг хэрэгжүүлж, цахим орчны дээрэлхэлтийн түвшин буурсан байна.
- ✓ Бүх нийтийн цахим орчны зохистой хэрэглээг бий болгосон байна.
- ✓ Мэдээллийн технологийн салбарын хүний нөөц бэлтгэгдэх суурь бүрдсэн байна.
- ✓ Аймгийн цахим шилжилтэд эерэг нөлөө бий болж, үр дүн сайжирсан байна.

_____оОо_____